



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар Б/98

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.1.1, Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1 Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11/52 тоот албан шаардлагаар "Хэнтий-Ус" ХХК нь 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай дүгнэлттэй гарсан тул "Хэнтий-Ус" ХХК-ий захирал Г.Батгэрэлд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг "Хэнтий-Ус" ХХК-ий захирал Г.Батгэрэлд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА